



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/256

Сүхбаатар сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын
хугацааг сунгаж хэвийн горимд
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "ж", "л", 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Улсын онцгой комиссын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 29 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэн хугацааг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасугай.

2.Соёл урлаг, нийтийн арга хэмжээ, худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газруудын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлж, бизнесийн үйл ажиллагааг дэмжин ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Халдвар хамгааллын дэглэмийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/249 дүгээр тушаалаар батлагдсан журмыг чанд мөрдөн ажиллахыг нийт аж ахуй нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, Мэргэжлийн хяналтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баттүвшин/, Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа /Б.Энхбаатар/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ